

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Дотоодын өрсөлдөөнт тендер шалгаруулалт

Огноо:	2018 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр
Төслийн дугаар, нэр:	P152343: Дэлхийн банкны санхүүжилттэй Эрчим хүчний төсөл - 2
Тендер шалгаруулалтын дугаар, нэр:	W-NCB-A-14-1: Багануур дүүргийн төвийн 6-0,4 кВ-ын цахилгаан түгээх сүлжээг шинэчлэх, сайжруулах ажил
Тендерийн материал ирүүлэх сүүлийн хугацаа:	2018 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн 15:00 цагт

- Энэхүү тендерийн урилга нь 2018 оны 2-р сарын 1-ний өдөр “Бизнесийн Хөгжил” дээр нийтэлсэн Төслийн Худалдан авах ажиллагааны Ерөнхий мэдэгдлийг дагуу зарлагдаж байна.
- Монгол улсын Засгийн газар нь Олон улсын хөгжлийн ассоциацийн зээлийн санхүүжилтээр Эрчим хүчний төсөл – 2 төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд, энэхүү төслийн хүрээнд W-NCB-A-14-1 дугаартай Багануур дүүргийн төвийн 6-0,4 кВ-ын цахилгаан түгээх сүлжээг шинэчлэх, сайжруулах ажил хийх худалдан авах ажиллагааг санхүүжүүлнэ.
- Эрчим хүчний яам эрх бүхий тендерт оролцогчдоос Багануур дүүргийн төвийн 6-0,4 кВ-ын цахилгаан түгээх сүлжээг шинэчлэх, сайжруулах ажил хийх зорилгоор битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.
- Тендер нь Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкны зээл болон Олон улсын хөгжлийн ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааны журам (2011 оны 1 дүгээр сар, 2014 оны 7 дугаар сард шинэчлэн боловсруулсан)-ын Дотоодын өрсөлдөөнт тендер шалгаруулалтыг дагуу явуулах бөгөөд Худалдан авалтын журамд тодорхойлсон эрх бүхий бүх тендерт оролцогчдод нээлттэй байна. Мөн Дэлхийн Банкны ашиг сонирхлын зөрчлийн талаарх бодлогыг тодорхойлсон 1.6 ба 1.7-р заалтыг үзнэ үү.
- Сонирхсон эрх бүхий тендерт оролцогч нь Төслийн удирдлагын газраас нэмэлт мэдээлэл авах, ажлын өдрийн Улаанбаатарын цагаар 09:00 – 17:00 цагийн хооронд урилгын төгсгөлд заасан хаягт хүрэлцэн ирж тендерийн баримт бичигтэй танилцах боломжтой.
- Дотоодын давуу эрх тооцохгүй. Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 5 жилийн борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь 1,854,542,826.00 (нэг тэрбум найман зуун тавин дөрвөн сая таван зуун дөчин хоёр мянган найман зуун хорин зургаан) төгрөгөөс багагүй байна. Сүүлийн 5 жилийн аль нэг жилд 3,700,000,000.00 (гурван тэрбум долоон зуун сая) төгрөгийн борлуулалтын орлоготой байна.
 - Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** 618,000,000.00 (гургаан зуун арван найман сая) төгрөгөөс багагүй байна.
 - Сүүлийн 5 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** Сүүлийн 5 жил буюу “2013, 2014, 2015, 2016, 2017” онуудын аль нэг жилд үндсэн гүйцэтгэгчээр нь 3,700,000,000.00 (гурван тэрбум долоон зуун сая) төгрөгөөс багагүй барилга угсралтын ажлыг гүйцэтгэж байсан туршилагатай байна.
 - Тусгай зөвшөөрөл:** Эрчим хүчний сайдын 03.2.3: 0,4-35 кВ-ын цахилгаан түгээх шугам, дэд станцын угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах үйлчилгээ.
Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгээс дэлгэрэнгүй шаардлагын үзнэ үү.
- Сонирхсон тендерт оролцогч нь урилгын төгсгөлд заасан хаягт хандан бичгээр хүсэлтээ гаргаж, 250,000 (хоёр зуун тавин мянган) төгрөг эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар хураамжийг эргэн үл төлөгдөх нөхцөлтэйгөөр төлсөнөөр тендерийн баримт бичгийг худалдан авч болно. Төлбөрийн данс:

Дансны нэр: Эрчим хүчний яам
Дансны дугаар: 100900030003
Банкны нэр: Төрийн сан банк.

Баримт бичгийг гадаад улсад илгээх тохиолдолд нэмэлт 150,000 (нэг зуун тавин мянган) төгрөгөөр буухиа шуудангаар хүргүүлэх болно. Эрчим хүчний яам нь баримт бичиг алга болох эсхүл хугацаа хоцорч хүргэгдсэнтэй холбоотой ямар нэг хариуцлага хүлээхгүй.

8. Тендерийг 2018 оны 11 дүгээр сарын 1-ны өдрийн 15:00 цагт эсхүл түүнээс өмнө урилгын төгсгөлд заасан хаягаар ирүүлнэ. Хугацаа хоцорсон тендерийг хүлээн авахаас татгалзана.
9. Тендерийн хамт Тендерийн баталгаа нь 74,181,750.00 (далан дөрвөн сая нэг зуун наян нэгэн мянга долоон зуун тавин) төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ. Тендерийг 2018 оны 11 дүгээр сарын 1-ны өдрийн 15:30 цагт доор заасан хаягаар хүрэлцэн ирж, нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдын төлөөллийг байлцуулан нээнэ.

*Хаяг: Монгол Улс, 17060, Улаанбаатар хот, ХУД, III хороо, Чингисийн өргөн чөлөө
Засгийн Газрын XIV байр, Эрчим хүчний яамны хурлын танхим*

10. Төслийн удирдлагын газрын хаяг:

*Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо
Чингисийн өргөн чөлөө-36, Гэгээнтэн оффис, 503 тоот
Эрчим хүчний яамны Эрчим хүчний төсөл-2
Худалдан авах ажиллагааны мэргэжилтэн Д. Туул
Утас:+976-77008544; И-мэйл: procurement@esp2.mn*